



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/25

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн эх үүсвэрээр хэрэгжих Мэргэжлийн хяналтын газрын барилгын засвар (Төв, Зуунмод сум) ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

С.Магнайбаяр - Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

С.Аюурзана - Төв аймгийн “Барилга захиалагч, орон сууцны корпораци” ОНӨААТҮГазрын инженер

С.Мөнх-Амгалан - Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Д.Дашдаваа - Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-н Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Тамирмаа - Төв аймгийн Орон нутгийн газрын худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (С.Магнайбаяр)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг чанд баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулахыг Аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Магнайбаяр)-д, шилэн дансанд мэдээлэхийг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

• 4122010039